



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

Г “Даваанбулаг” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд  
өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Баянгол дүүргийн шүүхийн 2007 оны 155 дугаар шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даваанбулаг” ХК-ийн нийт гаргасан 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 103,703/нэг зуун гурван мянга долоон зуун гурав/ ширхэг энгийн хувьцаанаас 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 69,066 /жаран есөн мянга жаран зургаан/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасч, тус компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 34,637 /гучин дөрвөн мянга зургаан зуун гучин долоо/ ширхэгээр тогтоосугай.

2. Тогтоолын 1 дэх заалтын дагуу 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 69,066 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан улсын бүртгэлд өөрчлөлт оруулж ажиллахыг “Даваанбулаг” ХК /С.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

00284